

Сумын Засаг даргын 2024 оны 09-р сарын 06-ны өдрийн 1/424 тоот албан бичгийн 1.-р хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2024 ОНЫ 3-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2024.09.26

Шивээговь сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, иргэд олон нийттэй харилцах 70546204 дугаарын утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

2024 оны 3-р улирлын байдлаар сумын Засаг даргад хандаж ирүүлсэн 31 өргөдлийг хүлээн авч 31 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Засаг даргад хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай 2 өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/23 дугаар захирамж, 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/77 дугаар захирамжаар, Асран хамгаалагчаар тогтоох тухай 2 өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/35, А/36 дугаар захирамжаар тус тус асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон.

Сумын "Хаялга спорт клуб"-ын өсвөрийн тамирчид Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдах "Самбо бөх"-ийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход унааны зардалд дэмжлэг хүссэн өргөдлийн дагуу Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/43 дугаар захирамжаар "Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал"-аас 350,000 (гурван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулж, дэмжлэг үзүүлсэн. Мөн буцалтгүй тусламж хүссэн 1 иргэний өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/49 дугаар захирамжаар эмчилгээний зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан.

Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын Гар бөмбөгийн эмэгтэй багийн тамирчид өөрсдийн хүсэлтээр өргөдлөөсөө татгалзсан.

Хаялганы усны баруун талд Төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар газар эзэмшдэг 2 иргэний газар эзэмших хугацаа нь дуусгавар болж байгаа тул тус

эзэмшлийн газруудын хугацааг сунгуулахад шаардлагатай тодорхойлолтыг сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/127, 1/128 тоот албан бичгүүдээр гаргаж өгсөн.

Худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар эзэмшдэг газарт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх талаар тодорхойлолт хүссэн өргөдлийн дагуу сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/221 тоот албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тодорхойлолт гаргаж өгсөн.

Сумын хэмжээнд цас их орсноос өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, хөдөөгийн багийн малчин өрхийн хашаа хороо цасанд дарагдаж, зам харгуй цасанд боогдсонтой холбогдуулан Сумын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон суманд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, Компанийг нийгмийн хариуцлагын хүрээнд дайчлан техник хэрэгсэл, хүн хүч ажиллуулан хөдөөгийн багийн малчин өрхүүдийн хороо бууцны цасыг түрж, зам гаргах ажлыг зохион байгуулж ажилласан.

Мөн өргөдөл өгсөн малчны хүсэлтийн дагуу Засаг даргын Тамгын газрын албан хаагчид тус малчин өрхийнд 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ажиллаж, хороо бууцны хөлдүүсийг цохиж цэвэрлэн улсаас хөнгөлөлттэй болон үнэгүй олгохоор хуваарилагдсан өвс, тэжээлийг ачин хүргэж өгч, 5 кг гурил, 2 шуудай хивэг, үхрийн 4 нэмнээний тусламж үзүүлсэн.

Гэр хүссэн 1 иргэний өргөдөлд гэр олгох боломжгүйг мэдэгдэж, өргөдлийг хяналтанд авсан.

Газрын хэмжээг өөрчлөх тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/68 дугаар захирамжаар газар өмчлөх шийдвэрт өөрчлөлт оруулсан.

Үйлчилгээний болон Өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшдэг газрын газар эзэмших хугацааг сунгуулах тухай 2 өргөдөл ирснийг хянаж үзээд газар эзэмших эрхийн хугацаа нь 2022, 2023 онуудад дууссан байсан тул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Улсын байцаагчид өргөдөл болон холбогдох материалыг шилжүүлсэн.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг 2024 онд багтаан хийлгэх тухай өргөдөл ирсний дагуу 2024 онд багтаан дүгнэлтийг гаргуулж болох талаар хариуг мэдэгдсэн.

Газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчилсөн захирамж гаргуулах тухай өргөдлийн дагуу сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/105 дугаар захирамжаар “Загас үржүүлэг”-ийн зориулалттай 3 га газрын зориулалтыг “Аялал жуулчлалын бааз” болгон өөрчилсөн.


Өвөлжөө, хаваржааны газар хүссэн 2 өргөдлийн дагуу судалж үзэхэд тус хүссэн газар нь “Эйкүсора” ХХК-ийн ашиглалтын газартай давхцаж байгаа тул эзэмшлээр газар олгох боломжгүйг мэдэгдэж сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 1/421 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшдэг газраа өмчлөхийг хүссэн 2 өргөдлийг судалж үзэн сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 1/422 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшихийг хүссэн 5, Газрын зориулалт өөрчлөх тухай 1, Үйлчилгээний зориулалтаар газар эзэмшихийг хүссэн 1, Эзэмшлийн газар хүссэн 1, Эзэмшлийн зориулалтаар авсан газрыг өмчлөлийн зориулалт болгох тухай 1, Хоршооны үйлчилгээ явуулахаар газар эзэмшихийг хүссэн 1 өргөдлийн дагуу сумын 2025 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, сумын ИТХ-ын 2024 оны жилийн эцсийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн.

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ



Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 09-р сарын 06-ны өдрийн 7/464 тоот албан бичгийн 04-р хавсралт



2024 оны 3-р улирлын байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, социал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Шивээговь сум	0	0	0	0	31	0	0	0	0

2023 оны 3-р улиралтай харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, социал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Шивээговь сум	0	0	0	0	45	0	0	0	0

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Санхүүгийн дэмжлэг, тусламж хүссэн	3	9.70	Тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр гаргах
2	Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох	4	12.90	
3	Тодорхойлолт хүссэн	3	9.70	
4	Цасанд боогдсон замын цасыг түрж, хороо бууцны цасыг цэвэрлэх	1	3.20	
5	Газартай холбоотой	19	61.30	
6	Гэр хүссэн	1	3.20	
	Нийт	31	100.00	